

Алсын хараа - 2050
Гаалийн ерөнхий газар
/2024 оны 3 сар/

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хэрэгжилт /2024 оны байдлаар өссөн дүнгээр/	Хариуцсан газар
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА							
2	3.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	3.3.23. Экспорт, импортын зах зээлтэй холбоотой мэдээллийг цахимжуулж, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлж, бодлогоор дэмжинэ.	2020 - 2050	-		“Барааны экспорт, импортыг бүртгэх, статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг үндэслэн гадаад худалдааны 2023 оны урьдчилсан болон жилийн эцсийн гүйцэтгэл, 2024 оны 1, 2, 3, 4, 5 дугаар сарын барааны статистик мэдээлэл, динамик статистик мэдээллийг боловсруулж, гаалийн цахим хуудас www.gaali.mn/statistics сайтад тогтмол байршуулсан.	ГЕГ
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ							

18	4.1.Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно.	4.1.20. Экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудын бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг дэмжинэ.	2020 - 2050	-	<p>2024 оны эхний хагас жилийн байдлаар гаалийн хорио цээрийн хяналтад хамрагдсан экспортын барааны гаалийн мэдүүлгийн статистик мэдээнээс харахад: Нийт 963 аж ахуйн нэгж, 205 иргэний 1342 мэдүүлгээр экспортлогдсон бараа нь /цэвэр жин 72,8 мян.тн, бохир жин 74,1 мян.тн, 306,6 мян.доллар/ 338 автомашинаар, 71 чингэлгээр, 78 ТИР машинаар, 24 вагоноор, 548 онгоцоор тус тус тээвэрлэгдсэн байна. Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих ажлын хүрээнд: Мал, амьтан, ургамлын тэдгээрийн гаралтай 18 нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортлохын тулд БНХАУ-аас тавьсан шаардлагын дагуу 248, 249 дүгээр журмаар заавал БНХАУ-ын цахим бүртгэлд аж ахуйн нэгжүүд үйлдвэрээ бүртгүүлэхээр тусгасны дагуу гаалийн байгууллагаас 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн, экспортлох эрх хүсч хүсэлт гаргасан 11 аж ахуй нэгжийн холбогдох баримт бичигт хяналт хийж, баталгаажуулан ХХААХҮЯ-д уламжилсан. Гаалийн arqs.gaali.mn цахим системээр 829 аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан хүсэлт хүлээн авснаас мал, амьтны гаралтай бараанд экспортын гэрчилгээ 381 аж ахуйн нэгжид 1506 ширхэгийг олгож, БНХАУ-д 3853,5 тн адууны мах, 6426,5 тн дулааны аргаар чанаж боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, Иран, Ирак, Азербайджан, Узбекистан, Вьетнам улсад, 71,77,5 тн хонь, ямааны мах, БНХАУ-д адууны шир 135226ш, үхрийн хагас боловсруулсан цагаан шир 52300 ширхэгийг тус тус экспортлоход гаалийн хорио цээрийн хяналтыг хийсэн байна.</p> <p>2024 оны эхний хагас жилд Гаалийн ерөнхий газар болон гаалийн харьяа газар, хороодоос ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд нийт 903 ширхэг экспортын гэрчилгээ олгосноос ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 729 ширхэг, БНХАУ-д хивэг экспортлох гэрчилгээ 93 ширхэг, БНХАУ-д буудайн гурил экспортлох гэрчилгээ 81 ширхэгийг тус тус олгоод байна.</p> <p>Ургамлын хорио цээрийн хяналтын чиглэлээр нийт 92 аж ахуйн нэгж, 57 иргэний бараа экспортолдсоноос мэдүүлгээр 336, ангилалтын тоо хэмжээгээр 33,7 мян.тн, 1 мэдүүлгээр 778 литр, 7 мэдүүлгээр 18800 ширхэг бараа экспортлогдсон.</p>	ГЕГ
----	---	---	-------------	---	--	-----

“Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад байгалийн хадлан өвс экспортлох ургамлын эрүүл ахуйн шаардлагын тухай Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хоорондын протокол”-ын шаардлагын дагуу байгалийн хадлан өвс экспортлох хүсэлт гаргасан, Чинберри, Эксим минерал ресурс ХХК-иудын үйл ажиллагаанд хяналт хийхэд 2023 онд хадсан Чинберри ГХОК-ийн 8000тн, Эксим минерал ресурс ХХК-ийн 12000тн боосон хадлан өвс хадгалагдаж байгаатай холбогдуулан БНХАУ-ын ГЕГ-т албан бичиг хүргүүлэхээр ажиллаж байна. Байгалийн хадлан өвсийг Сүхбаатар аймгийн Бичигт боомтоор экспортлох тул ГЕГ-ын даргын 06 дугаар сарын 07-ны өдөр баталсан удирдамжаар тус боомтын “Гаалийн хяналтын бүс” байгуулах ажлын явцад хяналт хийсэн.

Мөн Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд экспортын эрдэс бүтээгдэхүүний /Чулуун нүүрс, хүрэн нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал, молебдений баяжмал, түүхий нефть/ өдөр бүрийн статистикийн мэдээллийг хүснэгт, инфографикийн дагуу өдөр бүр /176 удаа/ гаргаж хүргүүлсэн.

21	4.4.Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.	4.4.2. Бараа, үйлчилгээг худалдах, тээвэрлэх, хянах, хөрөнгө оруулах, зах зээлд нэвтрэх нөхцөлүүдийг ил тод болгох, бүртгэл ба мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, цаасгүй технологи нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан удирдлага ба хяналтыг бий болгоно.	2020 - 2050	-	<p><u>Хяналт бүрдүүлэлтийн чиглэлээр:</u> ГЕГ,ТЕГ болон ГТСМТТ УУГ хамтран “Гааль, татварын автомат бүрдүүлэлт”-ийн системд Гэрээ бүртгэлийн системийг шинээр хөгжүүлж бүрэн дуусгасан. Дээрх системд гадаад болон дотоод худалдааны гэрээ, боловсруулах, баяжуулах гэрээ зэрэг ашигт малтмалын бүх төрлийн гэрээг бүртгэх боломжийг бүрдүүлсэн. Мөн гэрээ бүртгэлийн нэгдсэн санд бүртгэгдсэн дотоод гэрээг цахим төлбөрийн баримтын системтэй холбож, төлбөрийн баримтыг цахимаар үйлдэх боломжтой болгосон. Гэрээ бүртгэлийн нэгдсэн системийн бодит орчинд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар 444 аж ахуйн нэгжийн үндсэн 4919 ашигт малтмалын гадаад худалдааны гэрээ, 848 нэмэлт буюу нийт 5767 гэрээг цахимаар бүртгэсэн байна. Гаалийн байгууллагын CAIS системд дээрх хугацаанд гэрээ бүртгэлийн нэгдсэн системээс татагдсан гэрээг үндэслэн 947826 ашигт малтмалын гаалийн бүрдүүлэлт хийж, 12132 гаалийн лабораторийн дүгнэлтийг гаргасан.</p> <p>2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар Гэрээ бүртгэлийн нэгдсэн системд нийт 4665 тээврийн гэрээ бүртгэгдсэн байна.</p> <p>Мөн 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс гэрээ бүртгэлийн системд экспортлогч аж ахуйн нэгж, тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан тээврийн гэрээг бүртгэх ажлыг туршилтаар нэвтрүүлсэн. Гэрээ бүртгэлийн нэгдсэн системд бүртгэгдсэн тээврийн гэрээг экспортын гаалийн бүрдүүлэлт хийх үед экспортлогч ААН-ын регистрийн дугаар, гадаад худалдааны гэрээ, тээврийн хэрэгслийн дугаар гэсэн утгуудаар хайлт хийж экспортын гаалийн мэдүүлэгт заавал хавсаргах хөгжүүлэлтийг ceps.gaali.mn болон gaali.mn дээр хийж нэвтрүүлсэн.</p> <p>Мэдүүлэг гааль зөвшөөрөв төлөвт ороход бараа бүртгэлийн нэгдсэн системрүү гаалийн мэдүүлгийн мэдээллийг, тээврийн гэрээний мэдээлэлтэй хамт илгээдэг болгож программын хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн.</p> <p><u>Гаалийн хорио цээрийн чиглэлээр:</u> Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг</p>	ГЕГ
----	---	--	-------------	---	--	-----

					<p>хангах арга хэрэгслийг сайжруулах” төслийн хүрээнд гаалийн хорио цээрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/115 тушаалаар өөрчлөлт оруулан шинэчлэгдэн баталсан. Ажлын хэсэг энэ хүрээнд хорио цээрийн эрсдэлийг, гаалийн эрсдэлийн удирдлагын модультай уялдуулах зорилгоор эрсдэлийн нэгдсэн журамд дурьдсан эрсдэл тооцох өгөгдлүүдийг цахимжуулах, төрийн байгууллагуудтай өгөгдөл солилцох, лабораторийн модулийн шаардлагын тодорхойлолт, гар утасны апплейкшнын загвар, хорио цээрийн модулийн цацраг, шарил, зорчигч, тээвэр, халдваргүйжүүлэлтийн дэд модульд засвар, сайжруулалт, хорио цээрийн хяналтын явцад буцаах мэдэгдлийн модулыг тус тус боловсруулсан. Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудаст нэмэлт өөрчлөлт оруулах, халдваргүйжүүлэлт, шарилын бүртгэл, түр тусгаарлалт, зорчигч, тээврийн хэрэгслийн эрүүл мэндийн хяналтыг захиргааны статистикийн бүртгэлийн мэдээнд оруулах программын даалгаврыг боловсруулсан.</p>	
--	--	--	--	--	--	--